



НҮҮРС ИЛ АРГААР ОЛБОРЛОХ MV-000287 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ
СУМЫН НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛДАГ ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Утас: (+976) 7535 5555
Факс: (+976) 9400 1619

Өмнөговь аймаг Цогтцэций сум Цагаан-Овоо баг
Тавантолгой Хувьцаат компани

www.tavantolgoi.mn
info@tavantolgoi.mn

БАТЛАВ:

БОАЖЯ-ны ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА _____ /Ц.УРАНЧИМЭГ/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

ТАВАНТОЛГОЙ ХК ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦГОЙ БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ
_____ /П.САЙНЗОРИГ/



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛДАГ ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/НҮҮРС ИЛ АРГААР ОЛБОРЛОХ МУ-000287 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ/
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 2016656/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын Ахлах шинжээч _____ /Ц.ЖАРГАЛНЭМЭХ/

Боловсруулсан:

ТАВАНТОЛГОЙ ХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн

_____ /Б.БАТ-АМГАЛАН/

_____ /Т.НАЦАГ/

Өмнөговь аймаг Цогтцэций сум

2022 он

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА

1	ТАВАНТОЛГОЙН УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
1.1	Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга:	6
1.2	Тавантолгойн бүлэг ордын геологийн тогтоц	7
1.2.1	Геологийн судалгааны түүх:.....	7
1.3	Тавантолгой ХК-ийн ТЭЗҮ, Байгаль орчны үнэлгээ, зөвшөөрлүүд.....	8
1.4	Уурхайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүтэц, нийт зардал.....	9
2	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ...	10
2.1	Агаарын чанар, тоосжилт	10
2.2	Газрын эвдрэл.....	10
2.3	Хөрсөн бүрхэвч	11
2.4	Гадаргын болон гүний ус.....	11
2.5	Ургамлын нөмрөг	11
2.6	Ан амьтан	11
2.7	Түүх соёлын дурсгалт зүйлс	11
3	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	12
4	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
5	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
6	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
7	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
8	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
9	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
9.1	Археологи, палеонтологийн тандан судалгаа	21
10	ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
11	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	23
12	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
13	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	25
14	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БОАЖГ-ЫН ЧИГЛЭЛ, ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	26

Хүснэгт

Хүснэгт 1	Тавантолгойн тусгай зөвшөөрлийн мэдээлэл.....	5
Хүснэгт 2	Тавантолгой ХК-ийн мэдээлэл	6
Хүснэгт 3	Тавантолгой ХК-ийн холбогдох албан тушаалтнуудын мэдээлэл.....	6
Хүснэгт 4	Тавантолгой ХК-ийн ТЭЗҮ.....	8
Хүснэгт 5	Байгаль орчны үнэлгээ	9
Хүснэгт 6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа	9
Хүснэгт 7	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
Хүснэгт 8	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	Error! Bookmark not defined.
Хүснэгт 9	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
Хүснэгт 10	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	18
Хүснэгт 11	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	19
Хүснэгт 12	Түүх, соёлыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20

Хүснэгт 13 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 14 Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө.....	23
Хүснэгт 15 Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө.....	24
Хүснэгт 16 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах	25


Зураг

Зураг 1 Тавантолгойн уурхайн байршил	5
Зураг 2 Тавантолгойн уурхай эхэлсэн түүхийн замнал.....	6
Зураг 3 MV-000287 талбай өмнөх судалгааны тайлангуудад хамрагдсан байдал	7

1 ТАВАНТОЛГОЙН УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харъяалал

Уурхайн байршил: Тавантолгойн уурхай нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан–Овоо багийн нутагт харъяалагддаг бөгөөд Улаанбаатар хотоос урагш 540 км, Өмнөговь аймгийн төвөөс зүүн тийш 100 км–т Цогтцэций сумаас баруун урд зүгт 15 км зайд байрладаг.



Зураг 1 Тавантолгойн уурхайн байршил

Ангилал: Тавантолгойн уурхай нь Тавантолгойн бүлэг ордын Цанхийн зүүн өмнөд хэсэгт хамаарах 276,9 га талбайгаас “Нүүрс ил аргаар олборлох” технологиор үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 1 Тавантолгойн тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Талбайн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Хэмжээ, га	Олгосон огноо	Аймаг, сум
Тавантолгой	MV-000287	276,9	2014.04.18	Өмнөговь, Цогтцэций
Газар зүйн солбицол нь:				
		105°28'41”	42°36'32”	
		105°28'41”	43°37'29”	
		105°28'43”	43°37'29”	
		105°28'43”	43°37'57”	
		105°27'55”	43°37'57”	
		105°27'55”	43°36'32”	

Аж ахуйн нэгжийн мэдээлэл:

Хүснэгт 2 Тавантолгой ХК-ийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр		Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил
Тавантолгой Компани	Хувьцаат	1110001005	Чулуун нүүрс олборлолт	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо баг

Хүснэгт 3 Тавантолгой ХК-ийн холбогдох албан тушаалтнуудын мэдээлэл

№	Нэр	Албан тушаал
1	П.Сайнзориг	Тавантолгой ХК Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгч
2	Б.Содномцэрэн	Тавантолгой ХК-ийн ХАБЭАБО албаны дарга
3	Б.Бат-Амгалан	Тавантолгой ХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн
4	Т.Нацаг	Тавантолгой ХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн


1.1 Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга:

“Тавантолгой” ХК нь өөрийн хөрөнгөөр 2011 онд MV-000287 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хяналт шалгалтын өрөмдлөг, геофизикийн судалгааны ажлуудыг хийсэн. АМГ-ын кадастрын албанаас 2014 онд MV-000287, MV-011945 гэсэн ашиглалтын тусгай зөвшөөрлийг нэгтгэн MV-000287 дугаартай нэг тусгай зөвшөөрөл болгосон тул энэхүү талбайд хамаарах нөөцийн тайланг шинэчлэн боловсруулж нөөцийг дахин тооцоолж ЭБМЗ-р хэлэлцүүлэн батлуулж, 2015 оны 6-р сарын 05-ний өдөр АМГ-ын даргын н/58 дугаартайгаар тус талбайн нөөцийг Ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.



Зураг 2 Тавантолгойн уурхай эхэлсэн түүхийн замнал

1.2 Тавантолгойн бүлэг ордын геологийн тогтоц



Зураг 3 MV-000287 талбай өмнөх судалгааны тайлангуудад хамрагдсан байдал

Тавантолгойн орд нь Монгол орны тектоник мужлалаар Говь-Тянь Шань террейнд хамаарах ба Өмнөд говийн нүүрсний сав газрын нэг хэсэг болох Улааннуурын хотгорын дүүрэгт оршдог. Уул зүйн хувьд Улаан нуурын хотгор Их Шанхын уулсын баруун урд үргэлжлэлд хамаарч, урдуураа Цэций уул, Их уул, хойгуураа Цагаан-Овоо, Нарийнхар нуруугаар хүрээлэгдсэн байдаг. Геоморфологийн хувьд хотойлтын бүс нь уулс хоорондын хотгоруудын тогтолцоог үүсгэдэг. Тэдгээр хотгоруудын тоонд (зүүнээс баруун тийш) Бортолгой, Улаан нуур, Ухаахудаг, Цанх, Баруун Наран ба Зээгт зэрэг дээд карбон-доод пермийн насны Дөш-Овоо, Цогтцэций, Зүүнбаян зэрэг формацын хурдсаас бүрдсэн, бие биеэсээ өргөгдөл, нугаралтуудаар тусгаарлагдсан байдаг.

1.2.1 Геологийн судалгааны түүх:

Ордын судалгаа шинжилгээний ажил 1950 оноос эхэлсэн боловч, Тавантолгой нүүрсний ордын хэтийн төлөвийг тогтоох, цаашдын судалгааны талбайг ялгах зорилго, чиглэл бүхий геологийн эрэл үнэлгээний ажил үнэн хэрэгтээ 1978 оноос эхэлжээ.

1977-1978 онд Тавантолгой орд дээр орон нутгийн зориулалтаар ашиглагдаж байсан уурхайг оролцуулан түүний эргэн тойрны талбайд Баянхонгорын гидрогеологийн экспедици (Ч.Гомбосүрэн, Д.Оросоо нар) нарийвчилсан хайгуулын ажлыг X давхраас (Хожуу үеийн судалгаагаар давхраас VIII гэж нэрлэгдсэн [3.4.7.8]) дээр явуулсан. Тухайн үеийн ТЭХҮГЯ-ны ШУТЗ-ийн хурлаар А зэргээр 2.1 сая тн, В зэргээр 2.2 сая.тн нөөцийг хүлээн авсан гэж тэмдэглэсэн нь байдаг ба судлагдсан зузаан 2.0-38.0 м, хөрс хуулалтын итгэлцүүр 1.1м³/тн. VIII давхраасын (уг тайланд X гэж нэрлэснийг хойшид VIII гэж нэрлэнэ) энэ хэсэгт хийсэн нарийвчилсан хайгуулын ажлаар А+В+С1 зэргээр 8006.6 мян.тн чулуун нүүрсний нөөц тооцоолсноос А зэргээр 2190.6 мян.тн, В зэргээр 2281.4 мян.тн, С1 зэргээр 3534.6 мян.тн тус тус тооцоолжээ

Энэ хүлээн авсан нөөцийн талбайн хүрээ, хожуу үеийн урьдчилсан болон нарийвчилсан хайгуулын ажлуудаар [3, 4, 5, 8] тухайн давхрааст тооцсон нөөцийн блокуудын хүрээтэй нийлдэг

тул нөөцийн давхцал гардаггүй. /АМГ-ын ГМТА, №2713/*ГМТА–Геологийн Мэдээлэлийн Төв Архив/

Тавантолгойн орд нь давхраасуудын байршлын налуугийн өнцөг багатай, нийлмэл тогтоцтой II бүлгийн ордод хамаарна. 1987-1988 онд Цанхийн хэсэгт (тусгай зөвшөөрлийн талбай хамрагдсан) гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулын ажлаар геологийн даалгаварт заасны дагуу 1200м түвшин хүртэл гүнд III ба IV давхраасуудын нөөц тооцохын тулд эхний ээлжийн олборлолтын нөөцийг тогтоосон.

1988-1990 онд Тавантолгойн ордын Цанхийн баруун ба зүүн хэсэгт нарийвчилсан хайгуулын, Бортээгийн хэсэгт урьдчилсан хайгуулын, Эрдэнэбулагийн ордын эрлийн ажлын хамт гүйцэтгэсэн. Геологи хайгуулын ажлаар нийт 62806.6 т.м баганат өрөмдлөг (296 цооног), 13330.0 т.м шнек өрөмдлөг, 15272.0 м3 суваг малталтын ажил гүйцэтгэжээ. Энэ ажлын дүнд Цанхийн зүүн, ба баруун хэсэгт гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулын ажлаар нийт 1073.5 сая.тн нүүрсний нөөц тогтоосноос коксжих нүүрсний нөөцийг 553.7 сая.тн, А зэргээр 18.9 сая.тн, В зэргээр 155.4 сая.тн, С1 зэргээр 350.7 сая.тн, С2 зэргээр 28.7 сая.тн, эрчим хүчний нүүрсний нөөцийг 463.5 сая.тн-оор, үүнээс А зэргээр 4.2 сая.тн, В зэргээр 58.8 сая.тн, С1 зэргээр 7.3 сая.тн, С2 зэргээр 49.0 сая.тн нүүрсний нөөцтэй гэж тооцож батлуулжээ.

“Тавантолгой” ХК-ийн MV-000287 тоот тусгай зөвшөөрлийн талбайд өмнөх судалгааны ажлуудын үр дүнд тооцоологдсон нөөцийн блокуудаас давхраас 0б.н, 0бс, 0б.в, 0в.н, 0в.в, 0г, II, III абв, IIIа, IVа, IVаб, IVб, V, Va, Vб, VII, VIIб, VIIа, VIII, VIIIа, VIIIв.дээд, VIIIв.дунд, IXаб, IXв-ийн зарим блокууд бүтнээр болон хэсэгчилэн ордог. Нийтдээ 8 давхраасын 26 нүүрсний үе багцын хэмжээнд 170 блокоор нөөцийг тооцоолсон. Тэдгээрийн 23 нь А, 22 нь В, 74 нь С1, 39 нь С2 нөөцийн блокууд, 12 нь P1 баялгийн блокууд юм.

Эдгээр блокуудын нийт нөөц 564,964.64 мян.тн бөгөөд үүнээс “Тавантолгой” ХК-ий MV- 000287 талбайд 178,219.01 мян.тн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ий MV-016882 талбайд 140,811.28 мян.тн, MV-011956 талбайд 48,493.22 мян.тн, MV-011943 талбайд 197,441.13 мян.тн нөөц тус тус хуваагдаж байна.

Харин MV-000287 талбайн нөөцийн шинэчилсэн тооцооны үр дүнгээр цэвэр нүүрсний хэмжээ нь А+В+С зэргээр 220,748.1 мян.тн, өгөршсөн нүүрс 801.1 мян.тн гэж тогтоогдсон ба үүнээс А+В зэргээр 149,420.6 мян.тн, С зэргээр 71,327.5 мян.тн болно. Нийт нүүрсний 8 давхраасын (0-IX давхраас, үүнээс I, VI давхраас тусгай зөвшөөрлийн талбайд ордоггүй) 26 үе багцын хэмжээнд 170 блокоор нөөцийг тооцоолсон. Тэдгээрийн 24 нь А, 81 нь В, 46 нь С нөөцийн блокууд, 12 нь P1, 2 нь P3 баялгийн блокууд өгөршсөн нүүрсний блокууд 5 юм.

1.3 Тавантолгой ХК-ийн ТЭЗҮ, Байгаль орчны үнэлгээ, зөвшөөрлүүд

Хүснэгт 4 Тавантолгой ХК-ийн ТЭЗҮ

№	ТЭЗҮ	Огноо	Гүйцэтгэсэн байгууллага
1.1	Шинэчлэн тооцогдсон нөөцийг ашиглах ТЭЗҮ-ийг боловсруулах ажил 2017 онд хийгдэж дууссан байна.	2017	Glogex ХХК

Хүснэгт 5 Байгаль орчны үнэлгээ

№	Үнэлгээ	Огноо	Гүйцэтгэсэн байгууллага
1. Ерөнхий үнэлгээ			
2.1	Тавантолгой ХК-ийн MV-000287 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий нүүрсний ордын ил аргаар ашиглах	2018.06.11	БОАЖЯ
2. Нарийвчилсан үнэлгээ			
3.1	Тавантолгой ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт хэрэгжиж буй MV-000287/А дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ	2018.06.20	“Глобал Энвайрон” ХХК

1.4 Уурхайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүтэц, нийт зардал

Хамрах хүрээ: Тавантолгой уурхайн MV-000287 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явагдаж байгаа үндсэн олборлолтын үйл ажиллагаанаас гадна ЭТТ ХК-ны үйл ажиллагаанаас үүдэж төлөвлөгөөт онд төлөвлөсөн ажлуудаас өөр ажлууд зайлшгүй байдлаар гарч ирдэг. Уурхайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндсэн олборлох үйл ажиллагаа болон тээвэрлэлт, гаалийн бүсэд хэрэгжих төслүүдтэй холбоотой ажлуудад байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг нэгтгэсэн болно. Үүнд:

1. Уурхайн лицензийн талбай: Тавантолгой ХК-ийн MV-000287 тусгай зөвшөөрөлтэй талбай
2. Бусад холбогдолтой ажлуудад

2023 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээ, нөхөн сэргээлтийн ажлын зардалд нийт 252.500.00 (хоёр зуун тавин хоёр сая таван зуун мянган) төгрөг төсөвлөсөн байна.

Хүснэгт 6 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа

№	Зардлын төрөл	Дүн (төгрөг)
1	Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв /технологийн зөв шийдэл/	0
2	Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	40.000.000
3	Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	49.000.000
4	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	34.000.000
5	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	0

6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	15.000.000
7	Түүх соёлын дурсгалт эд зүйлийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэх болон нөхөн олговор олгох арга хэмжээний төсөв	5.000.000
8	Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	35.000.000
9	Осол эрсдлийн менежмент	15.000.000
10	Хог хаягдлын менежмент	59.900.000
НИЙТ ТӨСӨВ		252.500.000

2 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Тавантолгой уурхайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан нөлөөллийн тодорхойлолтууд:

2.1 Агаарын чанар, тоосжилт

Төсөл хэрэгжих орчны агаарын чанарт нөлөөлөх гол хүчин зүйлүүдэд уурхайн олборлох ажиллагаа болон тээврийн замаас үүсэх тоосжилт, уулын тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтын хий, уурын зуухны галлагаа зэрэг эх үүсвэрүүд байна. Эдгээрээс орчны агаарт үүсэх тоосжилт, агаарын чанарт богино нөлөө үзүүлээд сарних сөрөг нөлөөлөл байна.

- Уурхайн хөрс болон нүүрс тээвэрлэлтийн зам, ачилтын талбайгаас үүсэх тоосжилт цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ордын хэмжээнд 2 – 4 км зайд бүрэн сарниж байна.
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн ажиллагаанаас агаарын чанарыг доройтуулна.

2.2 Газрын эвдрэл

Төслийн талбайг ерөнхийд нь уурхайн карьер, овоолго, гаалийн бүс, Тосгон, автозам, уурхайлалтын холбогдох объектуудын үндсэн зориулалтаар ашигладаг ба байгалийн ландшафтийн оронд үүсмэл ландшафт бүрдэх, газрын нөөц багасах, газрын гадаргын хэв шинжид өөрчлөлт бий болгоно.

- Төслийн талбайн объектууд, зам талбай эдэлбэрт өртсөн.
- Олборлолтын талбайд хотгор, гүдгэрийн эвдрэлүүд үүснэ.
- Хөрс хуулалт хийсэн талбайн ургамлан нөмрөг устсан.

Эдгээрийн нөлөөгөөр газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөлөл багаас их байх ба төслийн хэрэгжилтийн хугацаанд газрын ашиглалтын хэмжээ овоолгоор нэмэгдэж, газрын ашиглалтын зориулалтыг өөрчлөхгүй юм.

2.3 Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай нь хөрс газарзүйн мужлалтаар хөрс био – уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Говийн цайвар бор, Цөлийн бор саарал хөрс бүхий 12 – р тойрогт (Манлайн хөрсний тойрогт) багтана. Хөрсний үржил шимтг давхаргын зузаан бага, хөрс шавранцар бүрэлдэхүүнтэй учир механик болон техноген үйл ажиллагааны нөлөөгөөр элэгдэж эвдрэх нөхцөлтэй. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь уурхайлалтаас гадна төслийн талбайг төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн ашиглалтын талбайн бэлтгэл ажил хамарна.

- Уурхайн үйл ажиллагаагаар шимт хөрс эвдрэлд орсон.
- Хог хаягдлын хадгалалтын горим зөрчвөл бага зэргийн бохирдол үүснэ.

Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багаас дунд зэрэг байх ба ашиглалтын хугацаанд хөрсөн бүрхэвчийг нэмж хөндөхгүй.

2.4 Гадаргын болон гүний ус

Тавантолгойн ил уурхайн талбайд 2017 оны 10 сард хийсэн гидрогеологийн судалгааны дүнд Пермийн нүүрслэг хурдсанд агуулагдах уст үе, давхарга усжилт бага, багц шавхалтаар 1,5л/сек ундрагад усны түвшин төв цооногт 81,8м буурсан.

Уурхайн ашиглалтын жилүүд болон ахилтын түвшинд харгалзан тооцоолсон ус шүүрэх хэмжээ уурхайлалтын гүнээс шууд хамаарч зэргэлдээ орших “Эрдэнэс Тавантлогой ХК”-ийн ил уурхайн орд газрын ус шүүрүүлэлтийн нөлөөлөлөөс болж усны шүүрлийн усны хэмжээ харилцан адилгүй.

2.5 Ургамлын нөмрөг

Ашиглалтын нийт хугацаанд ил уурхай, хөрс, чулуулгийн овоолго хийх, уурхайн барилга байгууламж дор дарагдах зэргээр ургамлан нөмрөг шууд болон шууд бус нөлөөлөлд орж багаас дунд зэрэг гэсэн үнэлгээтэйгээр талхлагдана.

Төслийн хэрэгжилтийн хугацаанд ашиглалтанд өртөх газрыг бэлчээрийн зориулалтаар ашиглах боломжийг тодорхой хугацаанд хязгаарлана.

2.6 Ан амьтан

Уурхайн үйл ажиллагаагаар амьтдын амьдрах орчин, экологид тоног төхөөрөмжийн механик ажил, доргилт, дуу чимээ, техникийн хөдөлгөөн, шатахуун тосны үнэр зэрэг техногений шинжтэй нөлөөллүүдээс амьтад дайжих байдлаар нутгаа өөрчлөх, үүрлэж төллөдөг газраа өөрчлөх, байнгын стресст орох, идэш тэжээлээ хайх зэрэгт өөрчлөлт орох нөлөөтэй. Төсөл хэрэгжих хугацаанд амьтдын шилжин суурьших боломжийг бага зэрэг хязгаарлана.

2.7 Түүх соёлын дурсгалт зүйлс

Уурхай бүс нүүрс тээвэрлэлтийн газруудад судлагдсан түүх, соёлын дурсгалууд байхгүй бөгөөд шууд өртөхгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн судлаачдын багтай хамтран ажиллаж, заавар, зөвлөгөө авч ажиллана.

3 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго, зорилт 2023 оны байгаль орчны менежментийн үйл ажиллагааны гол зорилго бол уурхайн нүүрс олборлолтын үйл ажиллагаа, тэдгээртэй холбоотой үйл ажиллагаанд байгаль хамгааллын ажлыг үр дүнтэй зохион байгуулахаар төлөвлөсөн. Энэхүү зорилгын хүрээнд дараах арга хэмжээг хүргүүлж байна.

1. Орчны хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлэх
2. Уурхайн тоосжилтыг бууруулах
3. Хог хаягдлыг менежментийг хэрэгжүүлэх
4. Дүйцүүлэн хамгаалах аргыг оновчтой хэрэгжүүлэх
5. Үйл ажиллагааны явцад учирч болох эрсдлийн менежментийг хэрэгжүүлэх

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа харьяа сум аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газрын ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмжийн дагуу төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн биелэлтийг нэг бүрчлэн дэлгэрэнгүй оруулсан.

4 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал төгрөг	Хэрэг-жүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаарын чанар	Агаарын чанарын тоос хэмжилтийг зориулалтын багажаар тогтмол хийх	Уурхайн бүс, завсрын бүс, тосгон	мг/м ³	Дотоод зардал	1	Дотоод зардал	Сар бүр	Агаарын бохирдлын тухай хууль
		Тоос хэмжилтийн дүнг үндэслэн хөрс барьцалдуулагч бодис цацах	Уурхайн бүс	тонн	Дотоод зардал	100	Дотоод зардал	2 удаа	Агаарын тухай хууль
		Асгаралтын иж бүрдэл	Уурхайн бүс	ширхэг	1.2 сая	15	10 сая	1 удаа	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
2	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох байгууллагаар гаргуулж гэрээ байгуулах усны нөөц ашигласны төлбөр хураамжийг сар бүр орон нутгийн төсөвд төвлөрүүлэх	Тавантолгой ХК	М3	-	-	8 сая	1-р улирал	Усны тухай хууль
		Цогтцэций сумын Цагаановоо хорооллын айл өрхийн унд ахуй уст цэг байгуулах	Цогтцэций сум	ширхэг	20 сая	1	20 сая	1-р улирал	Усны тухай хууль
3	Хөрсөн бүрхэвч	Шимт хөрсийг стандартын дагуу хуулах, хадгалах, хяналт тавих	Шимт хөрсний овоолго	мян .м ³	-	-	-	тогтмол	MNS 5916:2008
		Шимт хөрсний овоолгод хөрсний шинжилгээ хийлгэх	Шимт хөрсний овоолго	удаа	Дотоод зардал	4	Дотоод зардал	Улирал бүр	MNS 5916:2008
4	Газрын хэвлий /газрын хэвлий түүний баялагийн зүй зохистой ашиглалт	MV-000287 тоот тусгай зөвшөөрлийн талбайд болон талбайгаас гадна тусгай зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал, ус, ургамал ашиглахгүй байх	“Тавантолгой” ХК	-	-	1	-	Дотоод зардал	Ашигт малтмалын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал төгрөг	Хэрэгжүүлэх давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
5	Ургамлан нөмрөг	Хамгаалалтын зурвас байгуулах	Шинэ суурьшлийн бүс	га	Дотоод зардал	6	Дотоод зардал	1-3 улирал	Байгаль орчны тухай хууль
		Хамгаалалтын зурвас байгуулах бэлтгэл ажил гүйцэтгэх	Шинэ суурьшлийн бүс	га	Дотоод зардал	40	Дотоод зардал	Улирал бүр	Байгаль орчны тухай хууль
		Олон наст ургамал, эмийн ашигт ургамлын үрийн нөөцийн бүрдүүлэх	Цогтцэций сум	кг	Дотоод зардал	5	Дотоод зардал	2,3 улирал	Байгаль орчны тухай хууль
		Тосгон орчмын ногоон байгууламжийн усалгаа арчилгааг хийх	Тавантолгой ХК	тонн	Дотоод зардал	Дотоод зардал	Улирал бүр		Байгаль орчны тухай хууль
		МҮГ-ын талбайд үр болон мөчрөөр үрсэлгээ хийх	Номгон сум Дэрсэн ус баг Эрдэнэбулаг	га	Дотоод зардал	20	Дотоод зардал	1-3 улирал	Байгаль орчны тухай хууль
6	Амьтаны аймаг	Ан амьтадын дүрс бичлэг, зураг авах камерын тоог нэмэгдүүлэх	Цогтцэций сум	ш	1 сая	2	2 сая	1-3 улирал	Байгаль орчны тухай хууль
	Нийт						40 сая		

5 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Техникийн нөхөн сэргээлт	Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.8 заасны дагуу эвдэрсэн газрыг нөхөн сэргээх Нөхөн сэргээлт-2024 арга хэмжээний хүрээнд Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн сайжруулсан шороон замын нөхөн сэргээлт хийх	км	25	Дотоод зардал	Дотоод зардал	1-4 улирал	Байгаль орчны тухай хууль
2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний талбайд олон наст ургамал тарималжуулах	га	1-2	21.04 сая	49 сая	2-3-р улирал	Шимт хөрс хуулах хадгалах стандарт
	Нийт					49 сая		

6 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хугацаа давтамж ба	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Цэций уулын ОНТХ газар нутгийн ан амьтдыг хамгаалах, амьдрах таатай орчин бүрдүүлэх	Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Цэций уул	200 ш	20.000	4 сая	1,2-р улиралд	Байгаль орчны зохих хууль тогтоомж, стандарт,
2		Зэрлэг ан амьтдын тоо толгой өсөлт, хорогдлыг бүртгэх	Цэций уул	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	1-4-р улирал	
3		Малчдын нөхөрлөл, хоршоо дэмжсэн арга хэмжээ зохион байгуулах	Цэций уул	4 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	Улирал бүр	Усны тухай хууль тогтоомж
4		Гадаргын усны эх үүсвэр, ундаргыг хамгаалах, хаших	Цэций уул	600 м	50000	30 сая	600	30.27 сая
	Нийт					34 сая		

7 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.								
	Нийт							

8 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн осол, зөрчил, уурхайн нуралт гулсалт, шүүрлийн усанд унах болзошгүй аюул осол аваариуд	ХАБЭА-н сургалт, НБХХ өмсөх, хяналт тавих, зааварчилгаа өгөх	Тавантолгой ХК	300	Дотоод зардал	Дотоод зардал	Өдөр тутам	Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм, ХАБЭА дүрэм журам
2		Хөдөлмөрийн чадвар алдалтгүй, хүн цагийн бүртгэлийн алдагдуулахгүй ажиллах	Тавантолгой ХК	300	-	-	Өдөр тутам	Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм, ХАБЭА дүрэм журам
3		Нийт ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэг хийх	Тавантолгой ХК	300	Дотоод зардал	Дотоод зардал	1 удаа	Эрүүл мэндийн тухай хууль
4	Хөрс ургамал бохирдуулах	Асгаралтаас сэргийлэх талбай бэлдэх	Уурхай	1	15 сая	15 сая	1 удаа	
	Нийт					15 сая		

9 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12 Түүх, соёлыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Археологийн дурсгал	Түвдэнгийн Борын түүхэн дурсгалт газруудыг тохижуулах	Цогтцэций сум Билгэх баг	1	5 сая	5 сая	1 удаа	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2.	Палеонтологийн дурсгал							
	Нийт					5 сая		

ТҮҮХ, СОЁЛЫН ӨВ

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр түүний орчимд өмнө нь Монголын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн хийсэн судалгаанаас үзвэл түүх дурсгалын болон соёлын өв болох зүйл байхгүй болно.

Цаашид барилга байгууламж нэмж барих, өргөтгөх явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны Яамны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

9.1 Археологи, палеонтологийн тандан судалгаа

“Соёлын өвийг хамгаалах тухай” Монгол улсын хуулийн 2014 оны 5 сарын 15 ны өдрийн шинэчлэсэн найруулгын 5.1.1; 6.1.5; 16.7.1; 17.1.3,4; 27.2; 28-р зүйл, 38.2,3; 60.1.10-д заасны дагуу газрын хэвлийг эзэмших ашиглахад палеонтологийн хайгуул тандан судалгааны ажлыг хийлгэх шаардлагатай байдаг. Уг хуулийн зорилго нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Эртний хүн, эртний амьтан, бичил биетэн, ургамлын чулуужсан олдвор, ул мөр, тэдгээрийг агуулсан олдворт газар нь түүх соёлын дурсгалт зүйлд хамаарна.

Соёлын дурсгалт өвийн асуудал Өмнөговь аймгийн хувьд чухал асуудал бөгөөд тус аймагт соёлын чухал өв дурсгалууд нилээд олон бий. Тухайлбал, Баянзаг, Говь Гурван Сайхан Байгалийн цогцолборт газар, Хонгорын элс буюу Дуут Манхан зэрэг жуулчдад сайн танил болсон хэд хэдэн газар бий. Уурхайн тусгай зөвшөөрөл авсан талбайд мөн олборлох үйл ажиллагаа явуулах газрын ойролцоох газар соёлын чухал өв дурсгал байдаггүй.

10 ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 13 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийн арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал төгрөг	Тоо хэмжээ, хэмжих нэгж	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Ахуйн	Хог хаягдлыг ангилан ялгах тусгай зориулалтын савтай болох /хуванцар, цаас, шил, бусад/	Уурхай, тосгон	5.6 сая	36 ш	39.9 сая	1,2-р улирал	Хог хаягдлын тухай хууль
		Хог хаягдлыг ангилан ялгах, шатаах, ландфилл байгуулах төслийн ГЭЗҮ зураг төсөл	Цогтцэций сум	-	4 га	20 сая	1,2-р улирал	Хог хаягдлын тухай хууль
		Энгийн хог хаягдлын бүртгэл хөтлөх, төлбөр хураамжийг төлөх	Уурхай, тосгон	Дотоод зардал	тонн	Дотоод зардал	Улирал бүр	Хог хаягдлын тухай хууль
2	Үйлдвэрлэл	Эко шатаах зуух ашиглалтад оруулах	Цогтцэций сум	Дотоод зардал	1 ш	Дотоод зардал	1,2-р улирал	Хог хаягдлын тухай хууль
		Хог хаягдлын тусгай зориулалтын автомашинаар тээвэрлэлт хийх	Уурхай, тосгон	Дотоод зардал	тонн	Дотоод зардал	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль
3	Аюултай	Эмнэлэгийн хог хаягдал, дугуй, төмөр, аккумулятор, тос зэрэг эрх бүхий компанид нийлүүлэх, бүртгэлжүүлэх	Уурхай, тосгон	Дотоод зардал	тонн	Дотоод зардал	Улирал бүр	Хог хаягдлын тухай хууль
	Нийт					59.9 сая		

11 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 14 Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө

